

“БОРНУУР” ХК

2021 оны 12 дугаар сарын 24 өдөр

№21/07

Борнуур сум

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн санхүүгийн болон

үйл ажиллагааны тайлан

“Борнуур”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Борнуур” ХК-ийн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. 2021 оны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.МӨНХБАТ

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 онд Борнуур ХК-н дэлхий нийтэд гарсан цар тахалтай холбогдуулан үйл ажиллагаа нь хэвийн бус байдалтай явагдсан. Хөл хориотой үед компанийн дүрэм, дотоод журамуудыг дахин боловсруулж холбогдох бичиг баримтуудын төрийн албаны байгуулагууд руу хүргүүлэн хүсэлт тавьсан. Компаний гүйцэтгэх удирдлага засаглалын сургалтанд хамруулах ажлыг төвлөсөн боловч компани үйл ажиллагаа явуулаагүй, санхүүгийн хувьд хүндрэлтэй байсан тул хойшлуулсан. Одоогийн компанийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг шинээр тодорхойлох, санхүүжилт хөрөнгө оруулалт олох зорилгоор тодорхой судалгааны ажлууд хийгдэж байна. Мөн өр төлбөртэй байсан зарим аж ахуйн нэгжүүдтэй тооцоог дуусгасан. Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь олон жил хуримтлагдсан тооцоог төлсөн. Компанийн санхүүгийн үйл ажиллагааг хянах үүднээс Ай Жэй Эй Эич Аудитын компанитай гэрээ байгуулаж дүгнэлт гаргуулсан. Мөн Борнуур ХК-ны өмнөх удирдлагаас шинэ удирдлагад шилжүүлж өгсөн бичиг баримт газрын асуудал нь Төв аймгийн Захиргааны анхан шатны шүүх дээр газрын асуудлаар шүүхийн шатанд хэлэлцэж байгаа. Мөн компани үйл ажиллагааг сэргээх талаар хөөцөлдөж төсөл хөтөлбөр судлан ажиллаж байна.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

| | /мянган.төгрөгөөр/ | |
|---|--------------------|------------------|
| | 2019 | 2020 |
| ХӨРӨНГӨ | | |
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгөн хөрөнгө | 0.2 | 29.9 |
| Авлага | 18,240.9 | 18,240.9 |
| Татвар, НДШ-ийн авлага | | |
| Бусад авлага | | |
| Бараа материал | | |
| Урьдчилж төлсөн зардал/ тооцоо | 35,466.1 | 35,466.1 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 2,643.0 | 2,643.0 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 56,350.2 | 56,379.9 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 739,527.6 | 739,527.6 |
| Биет бус хөрөнгө | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 739,527.6 | 739,527.6 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 795,877.8 | 795,907.5 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| Богино хугацаат өр төлбөр | | |
| Дансны өглөг | 22,859.1 | 26,259.1 |
| Цалингийн өглөг | 3,629.8 | 3,629.8 |
| Татварын өглөг | 3,154.8 | 3,154.8 |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг | 4,605.7 | 4,605.7 |
| Банкны богино хугацаат зээл | - | - |
| Богино хугацаат өр төлбөр | | |
| Урьдчилж орсон орлого | - | - |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 34,249.4 | 37,649.4 |
| Урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат зээл | | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 34,249.4 | 37,649.4 |
| Эздийн өмч | | |
| Өмч / төрийн / | | |
| Өмч / хувийн / | 772,798.9 | 772,798.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| Хуримтлагдсан ашиг, (алдагдал) | (11,170.5) | (14,540.8) |
| Эздийн өмчийн дүн | 761,628.4 | 758,258.1 |
| Нийт өр төлбөр, өмчийн дүн | 795,877.8 | 795,907.5 |


Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

ОРЛОГЫН ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

| | /мянган.төгрөгөөр/ 2020 |
|--|-----------------------------------|
| Борлуулалтын орлого | - |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - |
| Нийт ашиг (алдагдал) | - |
| Бусад орлого | - |
| Борлуулалт маркетингийн зардал | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 3,370.3 |
| Санхүүгийн зардал | - |
| Бусад зардал | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз) | - |
| Бусад ашиг /алдагдал/ | - |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (3,370.3) |
| Орлогын татварын зардал | - |
| Татварын дараах ашиг (алдагдал) | (3,370.3) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (3,370.3) |


Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

| | /мянган.төгрөгөөр/ | | | |
|-----------------------------------|---------------------|--|-------------------------|------------|
| | Хувьцааг капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагд- сан ашиг | Нийт дүн |
| 2019 оны 12 сарын 31 | 772,798.90 | - | (11,170.50) | 761,628.40 |
| Гаргасан хувьцааг капитал | | | | |
| Залруулсан үлдэгдэл | 772,798.90 | - | (11,170.50) | 761,628.40 |
| Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | | | (3,370.30) | (3,370.30) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | |
| 2020 оны 12 сарын 31 | 772,798.90 | - | (14,540.80) | 758,258.10 |



Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“БОРНУУР” ХК

2021 оны 12 дугаар сарын 24 өдөр

№ 21/08

Борнуур сум

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Ноогдол ашиг тараахгүй

байх тухай

“Борнуур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Борнуур” ХК-ийн 2020 оны үйл ажиллагаанд үндэслэн ноогдол ашиг хувиарлахгүй байх тухай ТУЗ-ийн гаргасан 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01 тоот тогтоолыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.МӨНХБАТ

**“БОРНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2021 оны 02-р сарын 19-ны өдөр

№ 01


Борнуур сум

Ногдол ашиг хувиарлахгүй тухай.

Компанийн тухай хуулийн 46.5-г үндэслэн Тогтоох нь:

Нэг. Борнуур ХК-нь 2020 онд үйл ажиллагаа бүрэн явуулаагүйн улмаас алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТДОРЖ

“БОРНУУР” ХК

2021 оны 12 дугаар сарын 24 өдөр

№ 21/09

Борнуур сум

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН

ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны үйл ажиллагааны

төлөвлөгөө биелэлтийг батлах

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн явцыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.МӨНХБАТ

2021 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ЯВЦ

1. Маргаантай байгаа асуудлуудыг төрийн зохих байгуулагуудад хандаж шийдвэрлүүлэх.
2. Хувь хүн, албан байгууллагуудтай үүссэн өр авлагын асуудлыг шийдвэрлэх.
3. Тариалангийн газарт биохими, агрохимийн шинжилгээ хийлгэх
4. Төсөл хөтөлбөрийн гэрээ хэлцэл байгуулах

Төлөвлөгөөний биелэлтийн явц:

1. Борнуур ХК-ны эзэмшилд байсан газруудыг ШШГЕГ-ийн битүүмжлэлд байсан хугацаанд хувь хүн, аан-үүдэд эзэмшүүлсэн асуудлаар Борнуур сумын засаг даргын тамгын газарт удаа дараа газрын эрх сэргээх хүсэлт тавьсан боловч албан ёсны хариу өгөөгүй тул Төв аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт өгч хандан шүүхийн дагуу эрхийг сэргээхээр ажиллаж байна. Цар тахалтай холбогдуулан төрийн байгууллагын хяналтын шатны үйл ажиллагаа удаашралтай байгаа бөгөөд тухайн газрын маргаанаар давж заалдах шатны шүүхэд хэлэлцэж байна. Мөн өмнөх ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагаас хөрөнгө хүлээж авах явцад тодорхой хэмжээний хөрөнгө дутсан, нэмэлт тайлбар авах шаардлагатай байгаа бөгөөд хариу тайлбар хүлээн авсны дараа шүүхээр шийдүүлэх болсон.
2. Борнуур ХК-нь үндсэн үйл ажиллагаа нь газар тариалан бөгөөд газрын маргаантай асуудлаар газар тариалангийн ажил хийх боломж бүрдэхгүй байгаа учир хувь хүн, албан байгууллагуудын үүссэн өр төлбөрийн асуудлыг зээлэх журмаар зохицуулалт хийгдэж байгаа. Үүнд: Олон жил хуримтлагдсан МХБ-ийн жилийн хураамж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хуримтлагдсан төлбөр, үр тариалангийн сангаас зээлсэн төлбөрийн өрнүүдийг бүрэн барагдуулсан. Компанийн үйл ажиллагаанаас орж ирсэн орлогоор буцаан төлөх журмаар төлбөрийг буцаан бүрэн барагдуулна.
3. Тариалангийн газарт биохими, агрохимийн шинжилгээ хийлгэх талаар шинжлэх ухааны хүрээлэнд хүсэлт тавьсан газрын маргааныг асуудлыг бүрэн шийдвэрлэсний дараа шинжилгээг бүрэн хийхээр гэрээ байгуулсан.
4. Төсөл хөтөлбөрт хамрагдахаар талаар бүрэн судалгаа хийгдсэн санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж цаашид газар тариалангийн асуудлаар хөнгөлөлтэй зээл, үр тарианы хангалтанд хамрагдах болсон.

“БОРНУУР” ХК

2021 оны 12 дугаар сарын 24 өдөр

№ 21/10

Борнуур сум

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
 гишүүдийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг удирдлага болон “Борнуур”ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олонхийн санал авсан
Ердийн гишүүдээр:
 1. Ц.Нарангэрэл
 2. С.Мөнхбат
 3. Т.Хүрэлбаатар
 4. Б.Мөнхбаяр
 5. Ж.Шинийннэгэн
 6. Б.ТөмөрбарХараат бус гишүүдээр:
 1. С.Энхболд
 2. Э.Батдорж
 3. М.Занабазар

нарыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосоныг баталсугай.

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилон ажлуулах, цалин урамшуулалыг тогтоохыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэхийг даалгасугай.
3. Компанийг үр ашигтай удирдахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.МӨНХБАТ